



МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД ЗАМ,
ТЭЭВРИЙН САЙДЫН ХАРИУЦАН ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТУСГАГДСАН
ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ТОВЧ ТАЙЛАН

2025 оны 06 сарын 30

Улаанбаатар хот

**Нэг. Хяналт-шинжилгээний
зорилго, үндэслэл, арга зүй**

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын тусгагдсан хүрээний зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах, төлөвлөсөн арга хэмжээг хугацаанд нь хэрэгжүүлэх, зохион байгуулалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, Засгийн газарт хэрэгжилтийн явцыг тайлагнах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээний ажлыг гүйцэтгэлээ.

Улсын Их Хурлын 2024 оны 35 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд туссан зорилго, зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ, хяналт-шинжилгээний үзүүлэлтийн биелэлтийг гаргаж, Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын 6.1, 6.3, 6.4-т заасан арга зүйг баримтлан ажилласан болно.

**Хоёр. Төлөвлөсөн арга
хэмжээний хэрэгжилтийн явц**

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд зам, тээврийн салбарт хэрэгжүүлэхээр туссан 4 зорилтыг хэрэгжүүлэх нийт 53 арга хэмжээ туссан байна. Үүнд:

- Авто замын салбарт 3 зорилтыг хэрэгжүүлэх 38 арга хэмжээ;
- Төмөр замын салбарт 1 зорилтыг хэрэгжүүлэх 6 арга хэмжээ;
- Иргэний нисэхийн салбарт 1 зорилтыг хэрэгжүүлэх 6 арга хэмжээ
- Автотээврийн салбарт 1 зорилтыг хэрэгжүүлэх 1 арга хэмжээ туссан байна.

Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын дагуу үнэлэхэд Зам, тээврийн салбарт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээний хэрэгжилтийг харвал тэргүүлэх чиглэлийн 15 төсөл арга хэмжээний хэрэгжилт 46.21%-тай, 53 төсөл арга хэмжээний хэрэгжилт 44.93%-тай, Төсвийн ерөнхийлөн захирагчийн 4 үр дүнгийн шалгуур үзүүлэлт 100%-тай, 6 хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт 91.07%-ийн хэрэгжилттэй тус тус үнэлэгдлээ.

Зорилт тус бүрийн хэрэгжилтийн үнэлгээг харвал:

1. 1.5. Ачаа тээвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх 24 төсөл, арга хэмжээ 45.31%-ийн хэрэгжилттэй;
2. 1.6. Боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх 2 төсөл, арга хэмжээ 0-29%-ийн хэрэгжилттэй буюу ажил хийгдээгүй, санхүүжилт, хүрэх түвшин тодорхой бус;
3. 1.8. Дөрвөн улирлын аялал жуулчлалын дэд бүтэц, үйлчилгээг хөгжүүлэх 26 төсөл, арга хэмжээ 43.68%-ийн хэрэгжилттэй;



4. 2.1. Орон нутгийн эдийн засгийн чадамжийг нэмэгдүүлэх 1 төсөл арга хэмжээ 100%-ийн хэрэгжилттэй байна.

Гурав. Дүгнэлт

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан Зам, тээврийн сайдын эрхлэх асуудалд хамаарах 53 арга хэмжээний хэрэгжилтийн үр дүн дараах байдалтай байна. Үүнд:

3.1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 4 зорилтын 53 арга хэмжээний тэргүүлэх чиглэлийн хэрэгжилтийн дундаж үнэлгээ 46.21%, төсөл арга хэмжээний хэрэгжилтийн дундаж үнэлгээ 44.93%-тай буюу хэрэгжилтийн явц зорилтот түвшний 30-59 хувь буюу "үр дүн хангалтгүй" үнэлэгдлээ.

3.2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн шалгуур үзүүлэлтийн үнэлгээ 100 хувьтай, зорилт хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн дундаж үнэлгээ 91.07 хувьтай буюу зорилтот түвшний 85 хувиас дээш буюу "Үр дүн гарсан" байна.

Иймд Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний зам, тээврийн салбарын төсөл арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээнээс харахад шинээр хэрэгжих төсөл арга хэмжээ нь Монгол Улсын төсвийн тухай хуульд тусгуулахаар санал хүргүүлсэн боловч хасагдсан, санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллагад санал хүргүүлсэн, тендер зарласан боловч гүйцэтгэгч шалгараагүй, ТЭЗҮ, зураг төслийн шатанд, санхүүгийн урьдчилсан тооцооллыг хийж байгаа, Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн хүрээнд төслийн шинжилгээ хийж байгаа төсөл, арга хэмжээг "шалгуур үзүүлэлт"-д хүргэхийн тулд холбогдох арга хэмжээг эрчимжүүлэн ажилласнаар энэхүү төлөвлөгөөний хэрэгжилт хангагдах боломжтой гэж дүгнэж байна.

Дөрөв. Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан Зам, тээврийн салбарт хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

4.1. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд зам, тээврийн салбарын чиглэлээр тусгагдсан төсөл арга хэмжээ, тэргүүлэх чиглэл, ТНБД-ын баталсан уг арга хэмжээг эзэнжүүлэх төлөвлөгөөнд заасан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж ажиллан, үр дүнгийн үзүүлэлт, санхүүжилтийг үнэн, зөв тайлагнаж, тогтоосон хугацаанд Бодлого, төлөвлөлтийн газарт хүргүүлэн ажиллахыг Бодлогын хэрэгжилтийн зохицуулах газруудад;

4.2. Бодлогын баримт бичгүүдэд тусган, зам, тээврийн салбарт хэрэгжүүлэх бүтээн байгуулалтын чиглэлээр хийх төсөл арга хэмжээний "шалгуур үзүүлэлт", "хэмжих нэгж", "суурь түвшин", "зорилтот түвшин", "хүрсэн түвшин"-г Хяналт-шинжилгээ хийх журмын 6.1-д заасны аргачлалаар үнэлж, хэрэгжилтийн хувиар илэрхийлэн үр дүнг гарцын нөлөөгөөр бий болсон, эсхүл бий болох эерэг болон сөрөг өөрчлөлтөөр тодорхойлох боломжтой байдлаар төлөвлөн ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн газар болон Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газруудад;

4.3. "Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний 1.6 дахь хэсэгт заасан **"Боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх"** зорилтын хүрээнд тус яамнаас авч холбогдох арга хэмжээг эзэнжүүлээгүй, хэрэгжилт хангалтгүй үнэлэгдсэн, мөн



Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хавсралт “Тэргүүлэх чиглэл”-д туссан төсөл арга хэмжээг эзэнжүүлж, хэрэгжилтийг эрчимжүүлэн ажиллахыг БТГ-т;

4.4. Хяналт-шинжилгээ, үнэлгээний журам, үнэлэх аргачлал өөрчлөгдсөнтэй холбоотой Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрууд БТГ, ХШҮДАГ-тай хамтран батлагдсан бодлогын баримт бичгүүдийн шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшин, хэрэгжилтийн байдлыг хэлэлцэн, удирдлагад танилцуулах;

4.5. Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд туссан арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнахдаа “хүрсэн түвшин”-гийн гүйцэтгэлийн хувийг тайлагнаж хэвшихийг Төмөр замын бодлого, зохицуулалтын газар, Автотээврийн бодлого, зохицуулалтын газар, Иргэний нисэхийн бодлого, зохицуулалтын газарт тус тус зөвлөж байна.

---o0o---